



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханбогд сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2023/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өмнөговь аймаг

2023 он

Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

Ч.Баярсайхан

Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@gmail.com

Аудитын менежер: Г.Ганцэцэг

Утас: 88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com

Ахлах аудитор: Э.Нандинчимэг

Утас: 88883776 Цахим

хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.08.24 № 27  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХАНБОГД СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Б.ТОГОСМАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ханбогд сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй 681.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч тайлагнасан байна.

#### Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг” шинэчлэн тогтоосон, мөн 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл”-д өөрчлөлт орж цалингийн шатлал нэмэгдсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020113

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	410,898.7	818,927.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,466,690.8	4,929,219.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>4,877,589.4</b>	<b>5,748,147.6</b>
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,877,589.4	5,748,147.6
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,877,589.4</b>	<b>5,748,147.6</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	8,257,844.1	3,600,403.3
Үйл ажиллагааны зардлын дүн	2,143,635.2	2,729,845.1
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>6,114,208.9</b>	<b>870,558.2</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>6,114,208.9</b>	<b>870,558.2</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
Тайлант оны үр дүн	-	870,558.2
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>4,877,589.4</b>	<b>5,748,147.6</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	6,265,251.1	2,253,668.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,507,745.9	1,527,819.3
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>4,757,505.2</b>	<b>725,849.5</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	-	<b>(36,919.8)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,757,505.2</b>	<b>688,929.7</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,835.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	694,765.7
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,896,698.2</b>	<b>1,560,284.8</b>
Урсгал зардал	1,896,698.2	1,523,365.0
Хөрөнгийн зардал	-	36,919.8
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,896,698.2</b>	<b>2,110,331.5</b>
Улсын төсвөөс санхүүжих	-	106,449.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	391,533.5	210,220.9

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 25.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 3.2 сая төгрөгийн төлбөрийн акт, албан шаардлага, 22.7 сая төгрөгийн алдаанд зөвлөмж хүргүүлсэн.

### Төлбөрийн акт

Аудитаар тайлант онд 1.1 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөгдөөгүй бараа материал худалдан авсан зөрчилд төлбөрийн акт хүргүүлсэн.

### Албан шаардлага

2021 оны 3 ажилтны илүү цагийн хөлс болох 2.2 сая төгрөгийг 2022 оны 01 сард нөхөн олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### Зөвлөмж

#### 1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Авто тээврийн хэрэгслийн сэлбэгийн зардлыг техник ашиглалтын паспортонд бүртгээгүй, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд тавих дотоод хяналтыг хийгээгүй.

#### 2. Шатахууны зардалтай холбоотой асуудал

Тээврийн хэрэгслийн шатахуун тооцоонд №390 тоот тушаалын дагуу хүйтний нэмэгдэл болон эмнэлгийн зориулалтын тэргэнд шатахууны нэмэгдэл хувийг тооцоогүй зэрэг зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
ТШЗ	1	22.7										1	22.7
Төсөл, хөтөлбөр													
ЗГТС													
ТТЗ													
ТЕЗ													
Дүн	1	22.7										1	22.7

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТШЗ	2	3.3	1	1.1	1	2.2							
Дүн	2	3.3	1	1.1	1	2.2							

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ					1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>					<b>1</b>			